



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 04

Хажуу шинэ-Ус

Хамтарсан баг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийн зөрчлийг илэрүүлэх орон нутгийн тогтолцоо бүрдүүлэх зорилго бүхий "Хамтарсан баг"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч : сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: Халамжийн мэргэжилтэн

Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан

Эрүүл мэндийн төвийн эмч

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга

3 дугаар багийн Засаг дарга

4 дүгээр багийн Засаг дарга

Сумын Цагдаа

Иргэний төлөөлөл 1

Цэцрлэгийн эрхлэгч

Сургуулийн эмч

2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг багийн ахлагч сумын Засаг дарга (Т.Ариунаа)-д үүрэг болгосугай.

3. Хамтарсан баг тусгай төлөвлөгөө гаргаж хурлаар хэлэлцэн баталж, зохион байгуулсан ажил түүний үр дүнг хагас бүтэн жилээр сумын ИТХуралд танилцуулж байхыг сумын Засаг дарга (Т.Ариунаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 08 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б. ПҮРЭВСЭНГЭ